

## ӨМНӨД СОЛОНГОСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ТУХАЙ

Д.Энхтайван

Өмнөд Солонгосын аж үйлдвэрийн өнөөгийн өндөр хөгжилт, мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан үйлдвэр нь өндөр хөгжилтэй улс орнуудынхаас цаг хугацааны хувьд хожуухан эхэлсэн ч олон улсын санхүүгийн зээл, гадаадын хөрөнгө оруулалт, мөн АНУ-ын цэрэг эдийн засгийн бодлогын үр дүнд түүхийн богино хугацаанд амжилтанд хүрч чадсан бөгөөд үндэсний нийт бүтээгдэхүүнээ сүүлийн 30-аад жилд тогтмол өсгөж явна.

Өнөөдөр Өмнөд Солонгосын аж үйлдвэрийн хөгжлийн түвшинг дунд зэргийн хөгжилтэй улсуудтай харьцуулахад тэргүүн байранд, зарим нэг салбарын үзүүлэлтээрээ тэргүүн зэргийн хөгжилтэй улсын түвшинд хүрч чадсан байна.

50-аад оноос экспортын барааг голлож хөнгөн үйлдвэрээс нэхмэлийн үйлдвэрийг түлхүү хөгжүүлж тэр чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэж, хүнсний асуудлыг шийдвэрлэх үүднээс цагаан будааны тариалалтыг нэмэгдүүлснээр нийгэмийн амьдралын хэрэгцээ шаардлагыг хангах нэг томоохон хэсгийг шийдвэрлэж чаджээ.

Үйл явцын эхэн үед экспортын барааг үйлдвэрлэх улсын төлөвлөгөө тасарч байсан төдийгүй үйлдвэрийг хөдөлгөх гол хүчин мэргэжилтэй боловсон хүчний мэдлэг чадвар ч сул байв. Үүнтэй уялдаж 1967-72 оны хооронд аж үйлдвэрийн салбарт ажиллах өндөр мэдлэг боловсролтой боловсон хүчнийг бэлтгэж чадсан төдийгүй гадаадын хөрөнгө оруулалтанд тулгуурласан дотоод хэрэгцээгээ хангахад чиглэсэн хэлбэртэй ч гадагш хандсан үйлдвэр аж ахуйн хэлбэрт хувирч чадсан. Тухайлбал гадаад улс орнуудад бүтээгдэхүүнээ гаргадаг үйлдвэрүүдийг бий болгоход Өмнөд Солонгосын эрх баригчид ихэд анхаарч Японоос техник технологийг мэргэжилтэнтэй нь хамт оруулан чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэж АНУ болон

---

Д.Энхтайван ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

баруун Европын зарим нэгэн орнуудад гаргаж эхэлсэн байна.

1965 онд Өмнөд Солонгос, Японтой хамтран ажиллах гэрээ байгуулсан нь 1 Японы тэргүүний техник технологийг тус улсад өргөн оруулах бололцоог бүрдүүлж өгсөн. Японоос техник технологи төдийгүй мэргэжилтэнүүдийг урьж тэднээс суралцсан нь бүтээгдэхүүний чанарт шууд нөлөөлсөнийг тэмдэглүүштэй.

1962-72 оны хооронд Өмнөд Солонгос Японоос 496 зүйлийн техник технологийг оруулсан нь нийт техник технологийнх нь 65 хувийг эзэлж байв.2

Энэ үед Өмнөд Солонгосын аж үйлдвэрийн хөгжилтөнд АНУ ихээхэн нөлөө үзүүлснийг тэмдэглэх хэрэгтэй юм. 1969 онд АНУ, Өмнөд Солонгостой хамтран Японы шинжлэх ухаан, техникийн ололт амжилтын нууцыг нээх судалгааны газрыг байгуулж чадварлаг мэргэжилтнүүдийг тэнд ажиллуулжээ.3

Судалгааны ажил эхлээд нэн удалгүй Өмнөд Солонгосын засгийн газрын шийдвэрээр томоохон үйлдвэр аж ахуйн газруудын тоног төхөөрөмжийг шинэчлэх үйл явц өрнөж 1963 онд 12 млрд. 1969 онд 97 млрд.-ын хөрөнгө зарцуулжээ.4

1970 он гэхэд Өмнөд Солонгос нь экспортын үйлдвэрлэлийг голлосон эдийн засгийн удирдамжтай аж үйлдвэрийн хурдтай хөгжилтэй улс болж нэгэнт чадсан. Энэ үед хүнд үйлдвэрийг хөнгөн нэхмэлийн үйлдвэрээр орлуулж, мэргэжилтэй ажилтанаар бүрэн хангаж, электроникийн багаж төхөөрөмжийг химийн үйлдвэрүүдэд төвлөрүүлснээр 1970 он гэхэд 1605 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэжээ.5 Мөн машины үйлдвэр 455 нүүрс олдворлох, химийн үйлдвэр 261, төмөрлөгийн 130 гаруй үйлдвэр ажиллаж байжээ.6

1973 онд эрдэмтдийн хот байгуулснаар усан онгоц зохион бүтээх, электроник, нүүрс олдворлолт, далай судлалын ажлыг эрчимтэй явуулах боломжийг бүрдүүлж судалгааны иж бүрэн цогцолбор үүсч эрдэмтдийн хүчийг бүрэн нэгтгэж чадсан бөгөөд 1979 оны байдлаар шинжлэх ухаан техникийн салбарт 197,6 сая ам долларын хөрөнгө зарцуулсан байна.

1971 онд засгийн газрын шийдвэрээр Солонгосын цахилгааны хүрээлэнг (СХХ) судалгааны биеээ даасан нутагт болгожээ. Энэ нь Солонгосын засгийн газрын цахилгааны болон урт хугацааны бодлогын цөм болж чадсан.

80-аад оны эхэ үед Өмнөд Солонгосын дотоодын хэрэгцээт бүтээгдэхүүнээс автомашин 90%, трактор 60%, цэвэр усны онгоц 70%-ыг эзэлж 700 гаруй үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 40% нь дэлхийн түвшинд хүрч, 8 энэ үеээс эхлэн Өмнөд Солонгосын мэргэжилтнүүд гадаад улс орнуудад ажиллах болжээ.

80-аад оноос дэлхий нийтээр өрнөсөн шинэчлэгдсэн технологийн эрин үеийн үйл явцтай уялдуулан Өмнөд Солонгос нь техник технологио шинэчлэх 2000 он хүртэлх урт хугацааны төлөвлөгөөг зохиосон. Энэхүү төлөвлөгөөг амжилттай биелүүлэх үүднээс жижиг электроникийн шинэчлэгдсэн технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр өндөр электроникийн нарийн тоног төхөөрөмж, радио, телевизор, дуран авиа, суудлын автомашин нь Өмнөд Солонгосын гадаадад гаргадаг гол нэр төрлийн бүтээгдэхүүн болж, Зүүн Өмнөд Ази, Хятад зэрэг улс орны зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй байна.

80-аад оны сүүлч, 90-ээд оны эхэн үе гэхэд шинжлэх ухаан техникийн хөгжил дэвшилт 1 млрд. 600 мянган воны хөрөнгө зарцуулж, 9 гадаадын хөрөнгө оруулалт зохих хэмжээгээр нэмэгдсэн. Үүнтэй уялдуулж электрон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээрээ японыг гүйцэж түрүүлэх зорилт тавьж ажилласан бөгөөд машин, төмөрлөгийн үйлдвэрлэл нь дэлхийн түвшинд ойртож байгаа ажээ. Дуу шингээх орчин үеийн төхөөрөмж нь АНУ-ын түвшин тогтоох шалгалтаар японы ижил төрлийн нэрд гарсан фирмийнхээс чанарын хувьд илүү гэсэн үнэлэлт авч, дэлхийн зах зээлийн 85%-ыг эзэлдэг АНУ-ын тооцоолон бодох зарим нэгэн эд ангийг энд үйлдвэрлэж байна. Гэр аж ахуйн цахилгаан тоног төхөөрөмжүүдийг орон нутагтгуудад ч үйлдвэрлэх болжээ. Түний үр дүнд 1988 оноос электрон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээрээ дэлхийд 4 байранд орох болж 2,1 миллиард долларын ашигтай ажиллажээ. 10 Орчин үеийн хийц загварын суудлын машин үйлдвэрлэл нь 1980 он гэхэд 1,1 саяд хүрч дэлхийд 10-р байранд оржээ. Японоос анх

1970 онд төмөрлөгийн тоног төхөөрөмж оруулснаас хойш жилийн дундаж үйлдвэрлэл 1,5 сая болж дэлхийд 3-т орох болсон. Химийн нийллэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээрээ Японтой хүчтэй өрсөлдөж байна. 1973 оноос эхлэн усан онгоцны үйлдвэрлэлтээр дэлхийд 2-т ордог болсон.

Ийнхүү Өмнөд Солонгосын аж үйлдвэр түүхийн богино хугацааны дотор ихээхэн амжилт олж хөгжиж чадсан онцлогийг дурьдваас:

1. Олон чиглэлээр их хэмжээний тэргүүний техникийн технологи оруулсан.

2. Гадаадын хөрөнгө оруулалтыг засаг төрийн хяналтаар доор ихээр оруулсан.

3. Өндөр хөгжил бүхий улс орон тухайлбал АНУ, Японтой хамтарсан үйлдвэр аж ахуйн газрыг байгуулж мэргэжилтэн ажиллуулахын зэрэгцээ үндэсний өндөр мэдлэгтэй боловсон хүчин бэлтгэж чадсан.

4. Нэгэнт үйлдвэрлэн гаргасан алив бүтээгдэхүүнийхээ чанарт байнга анхаарч улам баталгаажуулж чадсан.

5. Өөрийн хүчийг голлож, шинжлэх ухааны зүй зохистой судалгааны орчинг буй болгож эрдэмтдийн хүчийг төвлөрүүлж, маш нарийн техник технологийг эзэшиж чадсаныг нэн түрүүлж нэрлэж болно.

Өмнөд Солонгос нь хэдийгээр хуваагдмал орны хувьд үндэсний нөөц баялаг багатай ч өөрийн хөгжлийн уламжлалт суурьт тулгуурлан аж үйлдвэрээ эрчимтэй хөгжүүлж, улам шинийг нээх алсын бодлого баримтлан 2000 он гэхэд аж үйлдвэрийн хөгжлөөрөө дэлхийн хэмжээнд 10-р байранд орох зорилготой ажилласны үр дүнд Азийн нэгт "Бар" гэж дуудах хэмжээнд нэгэнт хүрч чаджээ.

## НОМ ЗҮЙ

1. "Гадаад орон судлалын асуудал" сэтгүүл, Чанчун 1991. №2. 10-р тал.
2. Мөн тэнд
3. 12-р тал
4. "Facts about Korea" 1990, p 58.

5. Мөн тэнд

6. "Handbook of Korea" 1990, p-420.

7. Kim Kwang-suk and Park Joong-Kyung.

Sources of Economic 1963-1982 Seoul:  
Development institute. 1985, p-10.

8. Мөн тэнд.

9. "Гадаад орон судлалын асуудал" сэтгүүл Чанчун.

1981, №2. 20-р тал.

10. 21-р тал

11. Мөн тэнд